



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/105

Арвайхээр

Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын
нэгдсэн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, Засгийн газрын 1993 оны “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 57 дугаар тогтоолын 3 дахь заалт, 1996 оны “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоолын 4 дэх хэсгийн “г” заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2019 оны нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийг дүгнэж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдлагууд, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулан ажиллахыг Хууль зүйн салбар хариуцсан аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хэрэгжилтэд хяналт тавин, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т тус тус даалгасугай.


ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

011100243

Аймгийн Засаг даргын 2019 оны 02
дугаар сарын 7-ны өдрийн 111 дугаар
захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
АЖЛЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, нийтийг хамарсан эрх зүйн сургалтыг зохион байгуулах, хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол, хүртээмжтэй сурталчлах ажлыг нэгтгэн зохицуулахад чиглэгдэнэ.

| д/д | Агуулга, сэдэв | Хугацаа /улирал, сар/ | Хамрах хүрээ /зорилтот бүлэг/ | Хүрэх үр дүн | Зохион байгуулах байгууллага | Хамтран ажиллах байгууллага |
|--|---|-----------------------------|---|---|-------------------------------------|------------------------------------|
| Нэг. Төрийн албан хаагчдад чиглэсэн сургалт | | | | | | |
| 1.1 | Төрийн албаны тухай хууль, холбогдох журмуудын талаарх сургалт | 2 дугаар улиралд | Төрийн албан хаагчид | Хуулийг хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна. | Аймгийн ЗДТГ-ийн ТЗУХ, ХЭЗХ | Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 1.2 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалт | 3 дугаар улиралд | Төрийн албан хаагчид | Хуулийн хэрэгжилт нөхцөл хангагдах бүрдэнэ. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 1.3 | Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалт | 1-2 дугаар улиралд | Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнууд | Төрийн албан хаагчдын архивын талаарх мэдлэг ур чадвар дээшилсэн байна. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Архивын тасаг | Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд |
| 1.4 | Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сэдэвт сургалт | 2 дугаар улиралд | Төрийн албан хаагчид | Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сайжирна. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, НБХ | Төрийн байгууллагууд |
| 1.5 | Жендер ба хүний эрх сургалт | 2 дугаар улиралд | Төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд | Төрийн байгууллага дахь жендэрийн бодлого, чиглэл сайжирна. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | ХЭҮК |
| 1.6 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйн сургалт | 2 дугаар улиралд | Төрийн албан хаагчид | Төрийн албан хаагчдын ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн | Аймгийн ЗДТГ-ын НБХ | Холбогдох мэргэжлийн байгууллагууд |

| | | | | | | |
|--|---|---------------------|---|--|--|---|
| | | | | талаарх мэдлэг дээшилнэ. | | |
| 1.7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн сургалт | 3-4 дүгээр улиралд | Төрийн албан хаагчид | Төрийн албан хаагчид Худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ авсан байна. | Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ | Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд |
| Хоёр. Иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн сургалт | | | | | | |
| 2.1 | Улсын бүртгэлийн тухай хууль түүний эрх зүйн зохицуулалт | 2 дугаар улиралд | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд | Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ. | Улсын бүртгэлийн хэлтэс | Сумдын ЗДТГ |
| 2.2 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний эрх зүйн зохицуулалт | 1, 2 дугаар улиралд | Иргэд | Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ. | Эрүүл мэндийн газар | Сумдын ЗДТГ |
| 2.3 | Боловсролын үйлчилгээ, түүний эрх зүйн зохицуулалт | 2-4 дүгээр улиралд | Иргэд, ЕБС, МСҮТ-ийн сурагчид, эцэг, эхчүүдэд | Боловсролын үйлчилгээний талаарх мэдээллийг олгосон байна. | Боловсрол, соёл урлагийн газар | Сумдын ЕБС-ын захиргаа |
| 2.4 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн сургалт | 2-3 дугаар улиралд | Иргэд | Хуулийн хэрэгжилт хангагдана. | Хүнс, хөдөө аж ахуйн газар | Сумдын ЗДТГ |
| 2.5 | Байгаль орчны хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт хандлага | 2-3 дугаар улиралд | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд | Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Сумдын ЗДТГ |
| 2.6 | Татварын багц хуулийн талаарх сургалт | 1-3 дугаар улиралд | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд | Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Татварын хэлтэс | Сумдын ЗДТГ |
| 2.7 | Нийгмийн халамжийн харилцаа, эрх зүйн зохицуулалт | 1-3 дугаар улиралд | Иргэд | Иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн байна. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Сумдын ЗДТГ |
| 2.8 | Нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалт | Жилдээ | Иргэд | Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ. | Нийгмийн даатгалын хэлтэс | Сумдын ЗДТГ |
| 2.9 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, холбогдох эрх зүйн актын талаарх сургалт | Жилдээ | Зорилтот бүлгийн иргэд | Зорилтот бүлэгт бодитой мэдээллийг олгосон байна. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Сумдын ЗДТГ |
| 2.10 | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт | Жилдээ | Иргэд, олон нийтэд | Хуулийн хангагдах нөхцөл хэрэгжилт нэмэгдэнэ. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Сумдын ЗДТГ, АТГ-ын олон нийтийн зөвлөл |

| | | | | | | |
|--|---|--------------------|------------------------------------|--|---|---|
| 2.11 | Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн сургалт | Жилдээ | Иргэд | Хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Сумдын ЗДТГ |
| 2.12 | Газрын тухай хууль, газар өмчлөлийн талаарх сургалт | Жилдээ | Иргэд | Хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ. | Сумдын ЗДТГ | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |
| 2.13 | Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон архи, согтууруулах ундааны хор уршгийн талаарх сургалт | Жилдээ | Иргэд | Сургалт, мэдээллийг олгосон байна. | Сумдын ЗДТГ | Цагдаагийн газар Эрүүл мэндийн газар |
| 2.14 | Хүн амд үзүүлэх төрийн нийтлэг үйлчилгээ /ОСНАА, ус хангамж, нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эрх зүйн зохицуулалт, хог хаягдал гэх мэт/ | Жилдээ | Иргэд | Хууль, эрх зүйн мэдлэгийг олгосон байна. | Арвайхээр сумын ЗДТГ | Холбогдох мэргэжлийн байгууллагууд |
| 2.15 | Гамшгаас хамгаалах тухай тухай хуулийн сургалт | Жилдээ | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд | Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилнэ. | Онцгой байдлын газар | Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд |
| 2.16 | Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль | Жилдээ | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд | Холбогдох дүрэм журам, стандартын ойлголтыг өгсөн байна. | Стандарт хэмжил зүйн хэлтэс | Сумдын ЗДТГ |
| 2.17 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль | Жилдээ | Иргэд | Хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Сумдын ЗДТГ | Цагдаагийн газар |
| 2.18 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйн сургалт | 2 дугаар улиралд | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд | Холбогдох хууль, журмын хэрэгжилт сайжирна. | Сумдын ЗДТГ | Мэргэжлийн хяналтын газар |
| Гурав. Хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалт | | | | | | |
| 3.1 | Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалт | Жилдээ | ЕБС-ийн болон МСҮТ-ийн сурагчдад | Хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | ЕБС-ууд, МСҮТ |
| 3.2 | 2019 оны ЭЕШ-ын журам, их дээд сургуульд оюутан | 2-3 дугаар улиралд | ЕБС-ийн 12 дугаар ангийн | Журмын талаар нэгдсэн ойлголт мэдээлэлтэй | Боловсрол, соёл урлагийн газар | Сумдын ЗДТГ |

| | | | | | | |
|--|---|---------------------|---|---|--|--|
| | элсүүлэх журмын танилцуулга, мэдээлэл | | сурагчид, ЭЕШ-бүртгүүлэгчид | болсон байна. | | |
| 3.3 | Татвар төлөхийн ач холбогдол түүний эрх зүйн зохицуулалт | 2, 4 дүгээр улиралд | ЕБС-ийн болон МСУТ-ийн сурагчдад | Хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Татварын хэлтэс | ЕБС-ууд, МСУТ |
| 3.4 | Жендэр ба хүний эрхийн сургалт | 2-4 дүгээр улиралд | ЕБС-ийн болон МСУТ-ийн сурагчдад | Хүний эрхийн суурь ойлголтуудын талаар мэдлэгтэй болсон байна. | Аймгийн ЗДТГ-ын НБХ | ХЭҮК |
| 3.5 | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт | 1-2 дугаар улиралд | ЕБС-ийн болон МСУТ-ийн сурагчдад | Шударга зан үйлд суралцахад нөлөөлсөн байна. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | ЕБС-ууд, МСУТ |
| Дөрөв. Лекц, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, өдөрлөг зохион байгуулах | | | | | | |
| 4.1 | Хуулийн байгууллагуудын нээлттэй өдөрлөг арга хэмжээ | 2 дугаар улиралд | Иргэд | Хууль зүйн үйлчилгээг түргэн шуурхай нэг цэгээс хүргэсэн байна. | Аймгийн ГХУСАЗЗ Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Сумдын ИТХ, ЗДТГ |
| 4.2 | Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох журмын талаар хэлэлцүүлэг | 1 дүгээр улиралд | Архи, согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, иргэд, иргэний зөвлөл | Хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ. | Аймгийн ЦГ, МХГ | Аймгийн ЗДТГ-аарын ХЭЗХ |
| Тав. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах | | | | | | |
| 5.1 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн цуврал шторк, кинонууд | Жилдээ | Иргэд | Хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага |
| 5.2 | E-khutuch.mn цахим хуудасны танилцуулга мэдээллийг сурталчлах | Жилдээ | Иргэд | Мэдээлэлтэй болсон байна. | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага |
| 5.3 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн талаар нэвтрүүлэг | 2 дугаар улиралд | Иргэд | Хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зөвлөл | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага |
| 5.4 | Бусад хуулиудын танилцуулга, сурталчилгаа | Тухай бүр | Иргэд | Хууль, эрх зүйн мэдлэгийг олгосон байна. | Төрийн байгууллагууд | Орон нутгийн Хэвлэл мэдээллийн байгууллага |